

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЗАВХАН АЙМГИЙН

ХОХБТХэлтсийн дарга

Ж.БАТЦЭНГЭЛ

ГҮЙЦЭТГЭГЧ:

"ОРГАНИК АРХИТЕКТУР

МОНГОЛИЯ" ХХК захирал

Б.БАТБАЯР

**ЗАВХАН АЙМАГ, УЛИАСТАЙ СУМ, 150 ХҮҮХДИЙН ОРТОЙ 9 ДҮГЭЭР**

**ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫН ЗУРАГ, ТӨСӨВ**

**БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ**

2019 оны 12-р сарын 06-ны өдөр

Дугаар №001/245

Улаанбаатар хэт

### **Нэг. Ерөнхий нөхцөл**

1.1 Монгол улсын иргэний болон барилгын тухай хууль, мөн бусад хууль тогтоомжуудыг үндэслэн зураг төсөл боловсруулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү гэрээ нь зураг төсөл боловсруулах ажлын үнэ, чанар, гүйцэтгэх хугацааг эцэслэн тохирох үндэслэл болно.

1.3 Энэхүү гэрээг нэг талаас Завхан аймгийн Хөрөнгө Оруулалт Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж. Батцэнгэл /цаашид "Захиалагч" гэх/ нөгөө талаас барилгын зураг төслийн "Органик Архитектур Монголиа" ХХК-ийн захирал С.Батбаяр /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ нар Монгол улсын иргэний хуулийн 29, 31-р бүлгийг үндэслэн дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.4 Захиалагч байгууллагын хүсэлтийг үндэслэн **"Завхан аймгийн Улиастай сумын нутаг дэвсгэрт баригдах 150 хүүхдийн ортой 9 дүгээр цэцэрлэгийн барилга"**-ын зураг төсөв боловсруулах ажлыг **2019 оны 11-р сарын 01-ны өдрөөс 2020 оны 01-р сарын 05-ны өдрийн** хооронд хийж гүйцэтгэхээр тохиролцов.

1.5 Барилгын ажлын зураг гэдэгт ерөнхий төлөвлөгөө, барилга архитектуур, барилга бүтээц, халаалт агаар сэлгэлт, ус хангамж ариутгах татуурга, холбоо дохиолол, хүчит төхөөрөмж, төсөв зэрэг дотор ажлын зургууд багтана. Ажлын зургийг эхлэхийн өмнө архитектурын болон бусад үндсэн шийдлийг 2 тал харилцан зөвшөөрөлцсөн болно.

1.6 Барилгын угсралтын ажлын явцад зохиогчийн хяналт хийх ажлыг нэмэлт зохиогчийн хяналтыг гүйцэтгэх гэрээ байгуулан хийнэ.

### **Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг**

2.1 Зураг төсөв боловсруулахад шаардлагатай батлагдсан зургийн даалгавар, газар олголтын шийдвэр, газрын дэвсгэр зураг, техникийн нөхцлүүд, геологийн дүгнэлт зэргийг бэлтгэн **2019 оны 11-р сарын 05-ны өдрийн** дотор гүйцэтгэгчид өгнө

2.2 Зураг төсөл зохиох явцад өөрсдийн саналаар нэмэлт өөрчлөлт оруулах буюу гэрээний хугацааг өөрчлөх, гэрээг цуцлах шаардлага гарвал гүйцэтгэгчтэй хамтран гэрээг дүгнэж, гүйцэтгэсэн ажлын хэмжээнд санхүүжилт хийж асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

2.3 Зураг төслийн ажил дууссанаас хойш барилга угсралтын ажлаа болих эсвэл хойшлуулахаар шийдэх зэрэг нь төлбөрөөс зайлсхийх үндэслэл болохгүй.

#### **Гурав. Санхүүжилтийн нөхцөл**

3.1 Зураг төсөл боловсруулах ажлын үнийг эдүгээ Монгол улсад мөрдөгдөж буй БХБЯ-ны сайдын 2012 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 182-р тушаалаар батлагдсан Зураг төслийн ажлын жишиг үнэ БД 81-16-12-ийн заалтуудыг үндэслэн тооцож 29.460.000 /Хорин есөн сая дөрвөн зуун жаран мянган/ төгрөг байхаар хоёр тал тохиролцов.

3.2 Зураг төсвийн ажлын үнийн дүнг ажлын зураг иж бүрэн дуусч захиалагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын хоёр хоногт багтаан 100 хувь шилжүүлнэ.

#### **Дөрөв . Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

4.1 Захиалагчийн зөвшөөрсөн архитектур төлөвлөлтийн шийдлээр ажлын зургийг хийнэ.

4.2 Зургийн ажилд туслан гүйцэтгэхээр оролцох мэргэжлийн бусад аж ахуй нэгж, хүмүүсийг өөрөө сонгон удирдаж ажиллах бөгөөд Захиалагчийн өмнө зураг төсвийн ажлын хариуцлагыг дангаар хүлээнэ.

4.3 Зураг төсвийн архитектур төлөвлөлт, инженерийн болон техник технологийн шийдлийг шинжлэх ухаан, техникийн дэвшилттэй уялдуулан өөрийн орны нөхцөлд тохируулан шийдвэрлэхийн хамт Монгол улсад дагаж мөрдөж буй зургийн стандарт, барилгын норм ба дүрмийн шаардлагыг хангасан байна.

4.4 Захиалагч тал тухайн объектийн техникийн нөхцлийг гаргуулж гүйцэтгэгч талд хүлээлгэж өгөөгүй тохиолдолд зураг төсвийн батлагдах хугацааны хариуцлагыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.

4.5 Захиалагч тал гэрээний 3.1 болон 3.2 заалтыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд гэрээний гүйцэтгэх хугацааны хариуцлагыг гүйцэтгэгч тал хариуцахгүй.

4.6 Барилгын ажлын явцад зураг төсвийн баримт бичигт алдаа, зөрчил илрэх, тодотгол хийх шаардлага гарвал мэдэгдэл авснаас хойш 7 хоногийн дотор асуудлыг шийдэж өгөх үүрэгтэй.

#### **Тав. Захиалагч, гүйцэтгэгчийн харилцан хүлээх үүрэг**

5.1 Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд зураг төсвийн үнийн дүнгийн

0.3%-тай тэнцэх алдангийг буруутай талдаа ноогдуулах бөгөөд нийт алдангийн дүн нь гэрээний нийт дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

5.2 Талууд гэрээний биелэлттэй холбогдсон асуудлуудаар тохиролцсонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.


5.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд хувь тус бүр адил хүчинтэй болно. Гэрээнд талууд гарын үсэг зурж тамга дарагдсанаар хүчин төгөлдөр болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**


ЗАВХАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ  
АРХИТЕКТОР



Х.Дэлгэрдалай

Утас: 98112900

“ОРГАНИК АРХИТЕКТУР МОНГОЛИЯ”  
Менежер



А.Эрдэнэцэцэг

Харилцагч банк: Төрийн банк

Дансны дугаар: 103700626296

Утас: 96968968